

**ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						2022 Он	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
<b>Нэг.КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМЙН ХҮНДЭРЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>								
Цар тахлаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ.	ЗГҮАХ-1.1.2.2	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	2021-2024	ӨАГТМЭ	-	Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дараалал сэдвээр Коронавируст /КОВИД-19/ халдвартай үйлчлүүлэгчийг эмчлэх 50 ортой тасагт багаар орж, байрлан ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад ажлын байран дээрх сургалтыг хийсэн. 91 эмч, эмнэлгийн ажилтнуудад зааварчилгааг өгч ажилласан.	100%	
Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	ЗГҮАХ-1.1.3.1	Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	2020-2024	ӨАГТМЭ	100.0 Улсын төсөв	Эм зүйн албаны эмийн нөөцийн агуулахад ЭМС-ын 2022 оны 06 сарын 20-ны өдрийн 5/2958 тоот тушаалын дагуу нийт 312 нэр төрлийн 145.565.606 төгрөгийн өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис зэрэг хэрэгслүүд 2 сарын нөөцтэйгөөр тусгай хадгалах нөхцлийн дагуу хадгалагдаж байна.	100%	
Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулна.	ЗГҮАХ-1.1.3.3	Холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	2020-2024	ӨАГТМЭ	-	2022.01.19-ны “Коронавируст (Ковид-19) халдварын тандалт сэргийлэлтийн түр заавар” Түр зааврыг шинэчлэн батлах тухай” А/36 тоот тушаал, 2022.07.19-ны “Сармагчны цэцэг өвчний тандалт, оношилгоо, эмчилгээний түр заавар батлах тухай” А/376 тоот тушаалуудаар сургалт хийж коронавируст халдварын үеийн эмнэлгийн байгууллагын халдвараас сэргийлэх дэглэм, тусгаарлах	100%	

						тасгийн бүсий ялган ангилал, хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, тайлах зааврыг танилцуулж, дадлага сургуулилтыг хийж мэдлэгийг олгосон.	
<b>Хоёр. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	ЗГҮАХ-2.1	Эх, нярай, эмэгтэйчүүдийн эрт илрүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулна.	2020-2024	ӨАГТМЭ	21.0 Улсын төсөв	2022 оны 05 дугаар сарын 16-наас нярайн кабинет шинээр нээж үйл ажиллагааг эхлүүлснээс хойш 2752 нярайд эрт илрүүлэх хийхэд, зүрхний төрөлхийн гажиг 28, тархины усжилт 2, бөөрний төрөлхийн гидронефроз 2, тархины ховдлын цус харвалт 3, тархины том хэмжээний уйланхай 2 тус тус эрт илрүүлсэн. Төрөлхийн гаж хөгжлийг эрт илрүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд хамруулсан. Мөн 7241 нярайд түнхний мултралыг илрүүлэх хэт авиан шинжилгээ хийхэд В хэлбэр 312, С хэлбэр 26 илрүүлсэн байна. Сонсголын скрининг 7241 нярайд хийсэн	100%
Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж иргэн бүр урьдчилан сэргийлэх эрт илэрүүлэх, эрүүл мэндийн үзлэг оншилгоонд тогтмол хамрагдах нөхцлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж эрүүл идэвхитэй замьдралын хэв маягыг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	ЗГҮАХ 2.1.1	Жирэмсний хожуу үеийн хордлогыг эрт илрүүлнэ.	2020-2024	ӨАГТМЭ	-	Эрсдэлтэй жирэмсний тусламжийн тасаг, Амбулаторийн тасгаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдээс 65 жирэмсэн эхийг сонгон жирэмсний 19 долоо хоногтойд манас таталтын урьдчилсэн илрүүлгийн оношлогоог хэт авиан шинжилгээгээр илрүүлсэн.	100%

Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээ	2.1.1.1	“Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.	2021-2024	ӨАГТМЭ	-	“Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг, 2022 онд “Иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, дадлыг бий болгох ажлын удирдамж”-ийг тус тус баталж “Эрүүл мэндийнхээ төлөө – Алхангаа ярилцъя” аянд нэгдэж 2022 оны 06-р сарын 12-нд тус ажлыг хариуцан зохион байгуулж бэлтгэл ажлыг ханган ажилласан.Тус аяны хүрээнд үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээр алхаж буй ард иргэд болон аянд оролцож буй бусад байгууллага зэрэг нийт 300 гаруй хүмүүст мэдээлэл, зөвлөгөө өгч, нярайн хүүхэдтэй ээжүүдэд гарын бэлэг гардуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн хаврын мод тарих өдөр 2022 ны 05-р сарын 14-ний өдөр нийт 50 ажилтны бүрэлдэхүүнтэй 100 мод тарих ажлыг зохион байгуулалт хийж оролцсон.	100%
Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ	2.1.1.2	Эмч, эмнэлгийн ажилтнуудыг ВГВ-ын эсрэг вакцинаар үе шаттай дархлаажуулсан байна. Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтыг 90 хувьд хүргэх	2020-2024	ӨАГТМЭ	-	-Улирлын томуугийн дархлаажуулалтыг 2022.10.25-26-ны өдрүүдэд явуулж, 220 хүн тун вакцинаар ажилчдын дархлаажуулалт хамрууллаа. -Нярайн хэсэгт сар бүрийн сүүлийн өдөр дархлаажуулалтын сувилагчийг ээлжинд хонуулж ажиллуулан дархлаажуулалт хийлгэснээр төрсний дараах 24 цагийн доторх заавал хийх дархлаажуулалт 8236 буюу 99.3%-д хийгдсэн.	100%
Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд	2.1.1.3	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	ӨАГТМЭ	21.0 Өөрийн орлого	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчигээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар,	90 %

						эх хүүхдийн өвчлөл, эндэгдэлийг бууруулах зорилгоор 5 зорилтот 72 үйл ажиллагаанаас 34 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлт 90% хувьтай байна.	
Яаралтай тусламжын чанар үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ	2.1.4	Хүлээн авах хэсгүүдийг нэгтгэж нэгдсэн хүлээн авах тасгаар үйлчлүүлэх боломжтой болгож засвар хийнэ.	2020-2024	ЭМЯ	357.0 Улсын төсөв	Эрүүл мэндийн яамны 357 сая төгрөгийн санхүүжилтээр засварын ажлын зураг төслийг боловсруулж, 3 хэсэгт байршин ажиллаж байсан тасгуудыг нэгтгэн 2022 оны 06 дугаар сараас Нэгдсэн хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Нэгдсэн хүлээн авах яаралтай тусламжийн тасаг нь 2022 онд 54777 эхийг хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 19158 эхийг хэвтүүлэн тусламж үйлчилгээ үзүүлж, 5610 эхэд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100%
		Яаралтай тусламжийн сургалтанд /хөх код/ эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургана.	2020-2024	ӨАГТМЭ	3.0 Өөрийн орлого	2022 оны 05 дугаар сар, 11 дүгээр саруудад Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Амь тэнссэн үеийн зүрх амилуулах тусламжийн сургалт” сургалтыг зохион байгуулж, нийт 27 эмч сургагч багшаар бэлтгэгдэж, 56 эмч, 81 эмнэлгийн мэргэжилтэн 250 гаруй энгийн иргэдийг хамрууллаа.	100%
“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж орон нутагт хийгдэх оншилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан цахим эрт илрүүлэг эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэн	2.1.6	Эмнэлгийн цахим бүртгэлийн системтэй болно.	2020-2024	ӨАГТМЭ	18.0 Өөрийн орлого	Лаборатори удирдлагын систем, Захиалга удирдлагын систем, Цахим түүхийн систем, Тайлангийн нэгдсэн систем, Эмнэлгийн удирдлагийн систем, Хүний нөөцийн зэрэг нийт 6 багц 84 дэд цогц системийг 2022 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн 5-н сургагч багш 14 хоногийн хугацаанд ажиллаж манай байгууллага хэрэгжүүлж эхэлсэн. Карте цахим бүртгэлд эхний хагас жилийн байдлаар	100%

						даатгалаар нэхэмжлэгдсэн 35699 үйлчлүүлэгчийн өвчний түүхийг оруулсан.	
Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж эрсдлийн сан байгуулна.	2.1.7	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	2020-2024	ӨАГТМЭ	-	Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газраас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад 10 тусламж, үйлчилгээний 96 оношийн хамаарлын бүлгээр оролцож зохих шатанд тэнцсэн. Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газартай тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийн гэрээг 2022 оны 09-р сарын 08-ны өдөр гэрээгээ байгуулан ажиллаж байна.	100%
Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	2.1.8	Эм зүйч нар UPTODATE ашиглан эмийн эмчилгээнд хяналт тавина.	2020-2024	ӨАГТМЭ		Эмнэлзүйн эм зүйч нар Карте программ дээр орсон эмийн эмчилгээг хянаж эмийн захиалгыг баталж байгаа бөгөөд UPTODATE ашиглан эмчийн бичсэн эмийн эмчилгээг стандартын дагуу байгаа эсэх, нийцэл үл нийцэл байгаа эсэхийг өдөр тутам нэвтрэн орж хяналтаа тавьж ажиллаж байна.	85.7%
Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэлт хийж хүний нөөцийн чадвахыг нэмэгдүүлж нийгмийн хамгааллыг дэмжинэ.	2.1.9	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх	2020-2024	ӨАГТМЭ	-	Төгсөлтийн дараах сургалтанд эх барих эмэгтэйчүүдийн үндсэн мэргэжил эзэмшсэн их эмч 19, төрөлжсөн мэргэшлийн эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдлээр их эмч 3, мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтанд дурангийн мэс заслын их эмч 2, эх барих эмэгтэйчүүдийн хэт авиан оношлогооны судлалын их эмч 5, нийт төгсөлтийн дараах сургалтанд 32 их эмч бэлтгэгдэн төгссөн.	100%
“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж шинэ төрсөн хүүхдүүдэд хувьцаа эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	2.5.12	“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж шинэ төрсөн хүүхдүүдэд хувьцаа эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	2020-2024	ӨАГТМЭ	-	Таван богд групптэй хамтран “Таван богд капитал” банк бус санхүүгийн нэгдлээс шинээр төрсөн хүүхэд бүрт хувьцаа олгох талаар уулзалтын ажлын хэсэгт Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал оролцсон. Голомт банктай хамтран шинэ төрсөн хүүхэд бүрт хадгаламжийн дэвтэр гардуулах талаар гэрээ хийгдсэн. Хаан банк, Хас банктай хамтарч “Хуримтлалыг хэрхэн бий болгох	80%

						түүний ашиг тус” сэдвээр эмэгтэйчүүдийн тасгийн ажилчдад сургалт явуулсан.	
<b>Дөрөв. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж иргэд олон нийтийн оролцоог хангана.	4.1.8		2020-2024	ӨАГТМЭ	-	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн цахим хуудас /хандалт-/ болон веб сайт /хандалт-253734/ тогтмол ажиллуулж байна.	
Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож орон тоо цалин хөлсний зардлын төлөвлөлт хэрэгжилт хяналтыг сайжруулна	4.1.10		2020-2024	ӨАГТМЭ	-	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоонд бүрэн хамрагдаж цалин хөлсийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бодож олгож байгаа	80%

						<p>МЭНДИЙН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ БАГЦ СУРГАЛТ"-аар анхан болон дунд шатны сургалтанд амжилттай хамрагсан. МУ-ийн Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос олгодог "Жендэрийн дүн шинжилгээ ба бодлого төлөвлөлт" анхан болон дунд шатны сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан "Сургагч багш бэлтгэх сургалт"-д хамрагдаж амжилттай суралцаж 2 шатны гэрчилгээг гардан авсан. Цаашид байгууллагатаа болон эрүүл мэндийн байгууллагуудад жендэрийн сургалт хийх боломж бүрдсэн.</p>	
Нийт дундаж							96,2%

ХЯНАСАН:  
ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН  
ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

Н.БАТСАЙХАН

